



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 06 сарын 22 өдөр

Дугаар А/112

Улаанбаатар хот

Журам батлах тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Газрын нэгдмэл сангийн тоо бүртгэл хөтлөх журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Журмыг тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллага, нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт хүргүүлж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Кадастрын хэлтэс /П.Баянтүмэн/-т даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын “Журам батлах тухай” 2022 оны 165 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ж.БАТСАЙХАН



Газар зохион байгуулалт, геодези,
зураг зүйн газрын даргын 2023 оны
дүгээр тушаалын хавсралт

ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН ТОО БҮРТГЭЛ ХӨТЛӨХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү журмын зорилго нь Газрын тухай хууль, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд заасны дагуу газрын нэгдмэл сангийн тооллого хийх, тоо бүртгэл хөтлөх, мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх, өөрчлөлт оруулах үйл ажиллагааг нэгдсэн арга зүйгээр хангахад оршино.

1.2. Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (цаашид “агентлаг” гэх), аймаг, нийслэл, дүүргийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (цаашид “аймаг, нийслэл, дүүргийн Газрын алба” гэх), сумын газрын даамал, тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагууд энэхүү журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.

1.3. Газрын нэгдмэл сангийн үндсэн болон дэлгэрэнгүй ангилалд хамаарах газрыг тодорхойлох, тооллого хийх ажлыг “Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай” хуулийн 13.3-д зааснаар 5 жилд нэг удаа газар зохион байгуулалт, газрын кадастрын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллага, газрын нэгдмэл сангийн мэдээллийн санг хөтлөх, өөрчлөлт оруулах ажлыг аймаг, нийслэл, дүүргийн Газрын алба, сумдын Газрын даамал тус тус хийж гүйцэтгэнэ.

1.4. Газрын нэгдмэл сангийн ангиллын зурган мэдээллийг Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан геодезийн солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд үйлдэнэ.


1.5. Газрын нэгдмэл сангийн ангиллын тооллого, тоо бүртгэлийн ажилд өмнө бүрдүүлсэн газрын нэгдмэл сангийн ангиллын тоон мэдээлэл, мөн тухайн ажлыг гүйцэтгэх шаардлагыг хангахуйц агаарын зураг, хиймэл дагуулын зураг, байр зүйн зургийг суурь болгон ашиглана.

1.6. Газрын нэгдмэл сангийн тооллогыг газрын нэгдмэл сангийн ангилал, газар ашиглалтын зориулалтаар нь тоолж бүртгэх, мэдээллийг бүрдүүлэх, талбайн хэмжээг тооцох замаар явуулах бөгөөд тооллогын ажлын үр дүнгээр Газрын нэгдмэл сангийн мэдээллийн санг Улсын хэмжээнд засаг, захиргааны нэгж тус бүрээр бүрдүүлнэ.

1.7. Газрын нэгдмэл сангийн тооллого явуулах, мэдээллийн сан бүрдүүлэх ажилд газар зүйн мэдээллийн системийн програм хангамж /ArcGIS, Quantum GIS г.м/-ийг ашиглана.

Хоёр. Газрын нэгдмэл сангийн ангиллыг тодорхойлох, тооллого явуулах

2.1. Газрын нэгдмэл сангийн тооллогыг дараах 3 үе шаттайгаар хийж гүйцэтгэнэ.



а/ бэлтгэл ажлын үе шат

б/ хээрийн судалгаа, хэмжилт, тодруулалтын үе шат

в/ материал боловсруулалтын үе шат

2.2. Бэлтгэл ажлын үе шат

2.2.1. Бэлтгэл ажлын үе шатанд газрын нэгдмэл сангийн ангиллын тооллого хийхэд шаардлагатай дараах өгөгдөл мэдээ, материалыг цуглуулж, судална.

Үүнд:

- Өмнө хийгдсэн газрын нэгдмэл сангийн тооллогын тоон мэдээлэл;
- Газрын нэгдмэл сангийн ангилал тус бүрийн нэгж талбарын зураглал, түүний тоо бүртгэлийн хүснэгтэн мэдээ;
- Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийн зураг /тоон хэлбэрээр/;
- Тооллого, тоо бүртгэлийн ажилд суурь зураг болгон ашиглах зорилгоор шаардлага хангахуйц агаар, сансрын зураг;
- Тодотгол хийгдсэн 1:100000 масштабтай байр зүйн зураг;
- Суурин газруудын 1:1000 масштаб бүхий байр зүйн зураг;
- Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдөл, мэдээ;
- Тухайн нутаг дэвсгэрийн газрын нөхцөл, нөөц, газар ашиглалтын талаарх мэдээлэл, газрын нэгдмэл сангийн тайлан.

2.2.2. Тооллогын ажилд тухайн ажлын шаардлагыг хангахуйц нарийвчлал бүхий сүүлийн 2 жилийн хугацаанд авагдсан агаар, сансрын зургийг ашиглах бөгөөд тус зургаас тодорхойлж болох ойн сан болон усны сан бүхий газар, зам, шугам сүлжээний газар болон бусад ангиллын газруудыг урьдчилсан байдлаар суурин аргаар тодорхойлж, тоон хэлбэрт оруулна.


2.2.3. Бэлтгэл үе шатны үед тодорхойлж, тоон хэлбэрт хөрвүүлсэн өгөгдөл, мэдээ болон өмнө хийгдсэн судалгаануудын дүнгээр хээрийн хэмжилт, судалгааны үе шатанд ашиглах ажлын зураг бэлтгэнэ. Хиймэл дагуулын зургаас ангиллыг нь тодорхойлоход хүндрэлтэй газруудыг хээрийн судалгааны үед тодруулах зорилгоор ажлын зурагт тусгайлан тэмдэглэж өгнө.

2.2.4. Шаардлагатай нутаг дэвсгэрийн газрын кадастрын зураг, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийн зураг болон бусад холбогдох тоон мэдээллүүдийг Засгийн газрын тогтоолоор батлагдсан солбицлын нэгдсэн системд хөрвүүлж бэлтгэнэ. Мөн эдгээр судалгааны зурагнуудыг урьдчилан бэлтгэсэн ажлын зурагт оруулж, хээрийн судалгаа, тодруулалтын ажлыг гүйцэтгэхэд бэлдэнэ.

2.3. Хээрийн судалгаа, хэмжилт, тодруулалтын үе шат

2.3.1. Хийгдэж буй тооллого, тоо бүртгэлийн ажлын талаар тухайн орон нутгийн Засаг дарга, газрын асуудал хариуцсан албан тушаалтанд танилцуулан, хээрийн судалгааны ажлын явцад хамтран ажиллана.

2.3.2. Агаар, сансрын зураг, байр зүйн зургаас тодорхойлсон газруудыг шаардлагатай тохиолдолд газар дээр нь тодотгох байдлаар хэмжилт, зураглалыг



хийж, тухайн газрын хил заагийг тодорхойлох бөгөөд хэмжилтийн ажилд 5^{II} хүртэлх нарийвчлалтай электрон тахеометр, 2 долгионы GPS ашиглана. Газар дээр нь хэмжилт хийж тодорхойлсон цэгийн байрлалын алдаа нь тухайн хил заагийг зураглах масштабын 0.01-ээс ихгүй байна.

2.3.3. Хот, тосгон, бусад суурин газрын хилийн заагийг Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан эргэлтийн цэгүүдийн солбицлыг тодорхойлон, Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан норм, дүрмийн дагуу тэмдэгжүүлэх бөгөөд энэ ажлыг гүйцэтгэсэн талаарх мэдээллийг ажлын тайланд дэлгэрэнгүй тусгана. Тэмдэгжүүлсэн эргэлтийн цэгүүдийг сум, дүүргийн газрын асуудал хариуцсан албан тушаалтанд актаар хүлээлгэн өгнө.

2.3.4. Хээрийн судалгааны ажлын төгсгөлд тухайн ажлыг гүйцэтгэсэн талаарх тайланг бичиж, орон нутгийн Газрын алба, холбогдох албан тушаалтанд танилцуулан, дүгнэлт, акт үйлдэн баталгаажуулсан байна.

2.4. Материал боловсруулалтын үе шат

2.4.1. Материал боловсруулалтын үе шатанд хээрийн хэмжилт, судалгаа, тодруулалтын үе шатанд хийгдсэн хэмжилтийн үр дүнг боловсруулж, тоон зураглалд засвар оруулна.

2.4.2. Бэлтгэл болон хээрийн судалгааны үе шатанд хийгдсэн ажлуудын үр дүнгээр газрын нэгдмэл санг дэлгэрэнгүй ангиллаар нь ялган зурагласны дараа шугаман болон полигон мэдээллүүдийг зөв дараалуулан топологи үүсгэн талбайг тодорхойлно. Зургийг хүснэгтэн мэдээлэлтэй холбохын өмнө зөв топологи үүсгэн алдааг нарийн сайн шалгаж засварлах шаардлагатай.

2.4.3. Дээрх тоон зураглалыг үндэслэн газрын нэгдмэл сангийн дэлгэрэнгүй ангилал тус бүрийн байршил, хэмжээг шинэчлэн тодорхойлно.

2.4.4. Тооллого, тоо бүртгэлийн ажлын үр дүнгээр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж тус бүрээр газрын нэгдмэл сангийн ангиллын болон улсын тусгай хэрэгцээний газрын тайланг гаргана.

2.4.5. Газрын нэгдмэл сангийн тооллогыг шинэчлэн хийж, тоо бүртгэл хөтөлсөн тухай бичмэл тайланг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж тус бүрээр бичиж, хавтаст материал бүрдүүлнэ.

2.4.6. Зураглалыг тоон хэлбэрээр тус журмын 1-6 дугаар хавсралтуудад заасан стандартуудын дагуу бэлдэж, CD, DVD-д хуулбарлана. Мөн тооллогын ажилд ашигласан байр зүй, агаар, сансрын зургийг тоон байдлаар хуулбарлана.

2.4.7. Газрын нэгдмэл сангийн зургийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж тус бүрээр зохих масштабаар, ангиллыг шинэчлэн тогтоосон бичмэл тайлан, бичиг баримтыг хэвлэж бэлтгэнэ.

2.4.8. Газрын нэгдмэл сангийн ангиллын зурагт дүрслэгдэх ангилал тус бүрийн тэмдэглэгээ, тэмдэглэгээний өнгийг тус журмын 6 дугаар хавсралтын дагуу агентлагаас боловсруулсан газар зүйн мэдээллийн системийн програм хангамжийн **.style** өргөтгөлтэй файлын дагуу зурагт үзүүлнэ.



**Гурав. Газрын нэгдмэл сангийн үндсэн болон дэлгэрэнгүй ангилал,
тэдгээрийн хил заагийг тогтоох**

3.1. Газрын нэгдмэл сангийн үндсэн болон дэлгэрэнгүй ангилал, газар ашиглалтын зориулалт, хот тосгон, бусад суурин газрын дэлгэрэнгүй ангилалд хамаарах үйл ажиллагааны чиглэлийг тухайн журмын хавсралт 1, 2-ын дагуу зураглаж бүртгэн кодолж мэдээллийн сан бүрдүүлнэ.

3.2. Газрын нэгдмэл сангийн тоо бүртгэлийн нэгж талбар дэд талбарт хуваагдсан тохиолдолд уг журмын 3 дугаар хавсралтын дагуу кодлон зураглаж бүртгэнэ.

3.3. Хөдөө аж ахуйн газрыг зураглаж, бүртгэх

3.3.1. Хөдөө аж ахуйн газарт хамаарч буй өвөлжөө, хаваржааны доорх газраас бусад ангиллын газрыг тухайн ангиллын хил зааг болон тоо бүртгэлийн нэгж талбар бүрээр бусад газраас ялгарч буй хил заагаар зааглан байр зүйн болон агаар, сансрын зураг ашиглан тодорхойлно.

3.3.2. Тариалангийн газрын тооллого явуулахдаа урьд нь хийгдсэн тариалангийн газрын кадастрын зураглалыг ашиглаж болох бөгөөд хээрийн судалгааны үе шатанд тодруулалт хэмжилтийг заавал хийнэ.

3.3.3. Өвөлжөө, хаваржааны доорх газарт "өвөлжөө-хаваржааны хотны саравч, гэрийн буурь, өвс-тэжээлийн хашаа, мал нарладаг талбай, морины уяа, бие засах газар, үнс, хог хаях газар" зэргийг хамруулж, газар дээрх бодит хэмжээг тогтоон тооцож бүртгэнэ. Газар дээр нь хэмжилт хийх боломжгүй тохиолдолд холбогдох байгууллагаас тогтоосон норматив хэмжээг үндэслэн тогтоож болно.

3.3.4. Бэлчээр дэх уст цэгийн талбайд инженерийн болон энгийн уурхайн худаг, барилга байгууламж, тэдгээрийн дагалдах талбарыг газар дээрээ ялгагдаж байгаа байдлаар нь зааглан тогтоож бүртгэнэ. Тэдгээрийн хамгаалалтын бүсийг худгийн эргэн тойронд 50 метрийн радиусаар авах бөгөөд уст цэгийн доорх болон хамгаалалтын бүсийн талбайг давхардуулан бүртгэхгүй.



3.4. Хот тосгон, бусад суурины газрыг зураглаж, бүртгэх

3.4.1. Хот тосгон, бусад суурины газрын хилийн зааг /тэг гортиг/-ийг тогтоохдоо Хот тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан тогтоож зураглана.

3.4.2. Тухайн ангиллын газруудын тооллогын зураглал үйлдэхэд шаардлага хангахуйц, өмнө хийгдсэн Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдөл, мэдээ болон төв суурин газарт хийгдсэн 1:1000 масштабтай байр зүйн тоон зургийг ашиглан газар дээрх бусад ангиллын газраас ялгарч буй хил заагаар зааглан тодорхойлно.

3.4.3. Багийн төвийн доторх газруудыг тоо бүртгэлийн нэгж талбар бүрээр хэмжиж, ашиглалтын зориулалтаар нь хот тосгон, бусад суурин газрын дэлгэрэнгүй ангилалд тус тус хамааруулан, талбайн хэмжээг тооцон бүртгэнэ.

3.4.4. Амралт, аялал жуулчлалын газарт хүүхдийн зуслан, амралтын газар, аялал жуулчлалын бааз, рашаан сувиллын газрыг хамгаалалтын бүсийн хамт тооцож тодорхойлно.

3.4.5. Уурхайн газрын эзлэх талбайг тооцохдоо ашиглалтын лицензээр олгогдсон талбайтай уялдуулан олборлож буй ашигт малтмалын төрлөөр нь ангилан хэмжиж бүртгэнэ.


3.5. Зам, шугам сүлжээний газрыг зураглаж бүртгэх

3.5.1. Зам, шугам сүлжээний газрыг тухайн журмын хавсралт 1-ийн дагуу дэлгэрэнгүй байдлаар ангилах бөгөөд шугаман мэдээллийн талбайг тооцохдоо тус бүрийн асуудал хариуцсан байгууллагын мөрддөг норм, нормативыг баримтална.

3.5.2. Цахилгаан дамжуулах, хий, дулаан дамжуулах шугам сүлжээ, кабель шугамын доорх газрын талбайг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 97 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтад заасны дагуу авна /Хүснэгт 1/.

Хүснэгт 1. Шугам сүлжээний газрын зурвасын өргөн

№	Шугам сүлжээ тоног төхөөрөмж	Хүн оршин суудаггүй газраар өнгөрөх нөхцөлд	Хүн оршин суудаг газраар өнгөрөх нөхцөлд	Дэд станц, дулаан дамжуулах төв, хуваарилах	Газар дээр ил байрласан	Газар дор байрласан	Усан дор байрласан	Ой мод, цэцэрлэг дундуур өнгөрөх нөхцөлд
		Шугамын захын утаснаас хоёр тийш		Тал бүр тийш	Шугамаас хоёр тийш			Шугамын захын утаснаас 2 тийш
0	1	2	3	4	5	6	7	8
1	Цахилгааны дамжуулах шугам: а/ 1кв хүртэл	-	1-1.5 м	-	-	-	-	-



	б/1-20 хүртэл кв	10 м	2 м	10 м	-	-	-	2 м
	в/ 35 кв	15 м	4 м	15 м				3 м
	г/ 110 кв	20 м	5 м	20 м				3 м
	д/ 220 кв	25 м	6 м	25 м				4 м
	е/ 330-500 кв	30 м	10 м	30 м				5 м
2	Кабель шугам	-	-	-	-	1 м	100 м	-
3	Дулааны шугам а/ 500 мм хүртэл голчтой	-	-	5 м	3 м	5 м	-	-
	б/ 500 мм-ээс дээш голчтой	-	-	5 м	5 м	7 м	-	-
4	Үнсэн сан			30 м				

3.5.3. Тооллогын ажил хийх явцад газар доорх шугам сүлжээний тоон зураг, мэдээллийг бүрдүүлэх бөгөөд тухайн газруудын эзлэх талбайн хэмжээ нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж /аймаг, нийслэл, сум, дүүрэг/-ийн нутаг дэвсгэрийн талбайн хэмжээг тооцож, тайлан гаргахад хамаарахгүй.

3.5.4. Ус хангамж, ариутгах татуургын шугамын өргөнийг “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль”-ийн 17 дугаар зүйлийн 17.6-д “Төвлөрсөн ус хангамжийн дамжуулах, түгээх шугамын тэнхлэгээс хоёр тийш таван метрт хамгаалалтын зурвас тогтооно” гэж заасны дагуу авна.

3.5.5. Зам тээврийн зориулалттай газрын ангилалд автозамын доорх газрын талбайн хэмжээг тодорхойлохдоо олон улсын, улсын чанартай автозамын зурвасын өргөнийг Автозамын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 16 дугаар зүйлийн 16.2-д “Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто замын зурвас газрын өргөн 100 метр /замын тэнхлэгээс хоёр тийш 50 метр/, орон нутгийн чанартай авто замын зурвас газрын өргөн 60 метр /замын тэнхлэгээс хоёр тийш 30 метр/ байна” гэж заасны дагуу зураглан, талбайн хэмжээг тооцно.

3.5.6. Мөн орон нутгийн чанартай замын өргөнийг дээрх хуулийн 16 дугаар зүйлийн 16.3-д “Нийслэл болон хот, суурингийн авто замын зурвас газрын өргөнийг холбогдох норм, дүрмийн хүрээнд аймаг, нийслэлийн Засаг дарга тогтооно” гэж заасны дагуу тухайн нутаг дэвсгэрийн Засаг даргын захирамжаар тогтоосноор авна.

3.5.7. Төмөр замын эзлэх газрын хэмжээг Төмөр замын тээврийн тухай хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан журам, дүрэм, стандартад нийцүүлэн зураглаж талбайн хэмжээг тооцон гаргана.

3.5.8. Агаарын тээврийн болон усан тээврийн газрыг тоолж бүртгэхдээ тухайн газруудын газар дээрээ бусад ангиллын газраас ялгарах хил зааг, хашаа хайс зэргээр зааглан зураглаж бүртгэн талбайн хэмжээг тодорхойлон гаргана.



3.6. Ойн сан бүхий газрыг зураглаж, бүртгэх

3.6.1. Ойн сан бүхий газрыг тухайн журмын хавсралт 1-ийн дагуу дэлгэрэнгүй байдлаар ангилах бөгөөд ойгоор бүрхэгдсэн газрын байршил, хэмжээг агаар, сансрын зураг ашиглан тодорхойлно.

3.6.2. Ойн тэлэн ургах нөөц газрыг ойн захаас 100 м-ийн зайтайгаар талбайн хэмжээг тооцож, зураглан бүртгэлд оруулна. Ойн сан бүхий газарт хамаарах газрын талбайн хэмжээг гаргасны дараа ойн асуудал эрхэлсэн /мэргэжлийн/ байгууллагад танилцуулан санал авч баталгаажуулсан байх шаардлагатай.

3.6.3. Ой модоор бүрхэгдсэн ба ой тэлэн ургах нөөц газарт бусад дэлгэрэнгүй ангиллын газрууд байршиж байвал эзлэх талбайг тодорхойлж, ойн сан бүхий газрын эзлэх талбайгаас хасч, тухайн ангиллыг хамаарах газарт хамруулна.

3.6.4. Мод үржүүлгийн газар болон ойг өсгөн үржүүлэхэд зориулж хашиж хамгаалсан газрыг тоолж бүртгэхдээ тухайн газруудын газар дээрээ бусад ангиллын газраас ялгарах хил зааг, хашаа хайс зэргээр зааглан зураглаж бүртгэн талбайн хэмжээг тодорхойлон гаргана.

3.7. Усны сан бүхий газрыг зураглаж, бүртгэх

3.7.1. Усны сан бүхий газар нь 4 дэд ангилалд хуваагдах /Хавсралт 1/ бөгөөд усны сан бүхий газрын төрөл, хэмжээг мэргэжлийн байгууллагын мэдээлэл, эрх бүхий байгууллагын судалгааны материалууд, байр зүйн зургийн тодруулалт, хиймэл дагуулын зургийг үндэслэн тодорхойлно.

3.7.2. Хэрэв өмнө нь судалгаа хийгдээгүй тохиолдолд хиймэл дагуулын зураг, 1:100000 масштабтай байр зүйн зургийн тодотголд тэмдэглэгдсэнээр гол, мөрний өргөнийг тооцож, талбайн хэмжээг гаргана. Зурагт тэмдэглэгдээгүй тохиолдолд хээрийн судалгааны явцад гол, мөрний өргөнийг тодруулж, тодорхойлно.

3.7.3. Нуур, цөөрөм, тойрмын эргээс 10 метрийн зайтайгаар, булаг, шандыг 5 метрийн радиустайгаар талбайн хэмжээг тус тус тооцно.

3.8. Улсын тусгай хэрэгцээний газрыг бүртгэх

3.8.1. Улсын тусгай хэрэгцээний газрыг дэлгэрэнгүй байдлаар хавсралт 1-ийн дагуу ангилна.

3.8.2. Улсын тусгай хамгаалалттай газруудын хил заагийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр олгосон газрын хилийн зааг дотор нь газрын нэгдмэл сангийн дэлгэрэнгүй ангиллаар ангилан хэмжээг тодорхойлж бүртгэнэ.

3.8.3. Улсын хилийн зурвас газрын хил заагийг Монгол улсын Хилийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад заасны дагуу 15 км хүртэл хэмжээгээр холбогдох байгууллагаас тогтоож албажуулсны дагуу тооцож, бүртгэнэ.

3.8.4. Аймаг дундын отрын бэлчээр, Улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай, бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хайгуулын зориулалтаар ашиглах газрын тосны гэрээт талбай, чөлөөт бүсийн газар, цөмийн төхөөрөмж барих, ашиглах зориулалтаар олгосон газар, бичил уурхайн зориулалтаар олгосон газар, хилийн боомтын бүс, үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх газар, аюултай хог хаягдлын төвлөрсөн



байгууламж барих газар, хамгаалалтын бүс тогтоосон түүх, соёлын дурсгалт газрын хил заагийг эрх бүхий төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрийн дагуу зураглан, талбайн хэмжээг тооцож, бүртгэнэ.

3.8.5. Улсын тусгай хэрэгцээний газрын дэлгэрэнгүй ангиллын газрыг газар дээрх бусад газраас ялгарч буй хил зааг, олгогдсон газрын бодит байгаа хашаа, хайсны хэмжээгээр нь хэмжиж зураглан, бүртгэнэ.

Дөрөв. Газрын нэгдмэл сангийн мэдээллийн санд өөрчлөлт оруулах

4.1. Агентлагт улсын хэмжээний газрын нэгдмэл сангийн мэдээллийн сан тусдаа серверт байрлах бөгөөд агентлагийн Кадастрын хэлтсийн газрын нэгдмэл сангийн тоо бүртгэл болон улсын бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн газрын нэгдмэл сангийн улсын хэмжээний мэдээллийн сангийн үйл ажиллагааг эрхэлнэ.

4.2. 21 аймгийн Газрын албаны кадастрын асуудал хариуцсан мэргэжилтэн тухайн аймгийн бүх сумдын газрын нэгдмэл сангийн мэдээллийн санд өөрчлөлт оруулах асуудлыг хариуцан гүйцэтгэх бөгөөд сумдын газрын даамлуудыг тухайн мэдээ мэдээллээр ханган ажиллана.

4.3. Нийслэлийн Газрын албаны кадастрын асуудал хариуцсан хэлтсийн холбогдох мэргэжилтэн бүх дүүргүүдийн газрын нэгдмэл сангийн мэдээллийн санд өөрчлөлтийг оруулах бөгөөд дүүргийн Газрын албадыг тухайн мэдээллээр ханган ажиллана.

4.5. Газрын нэгдмэл сангийн мэдээллийн санд өөрчлөлт оруулж, мэдээллийн санг хөтлөх эрхийг агентлагийн даргын тушаалаар олгох бөгөөд тухайн эрх авах хүсэлтэд тухайн мэргэжилтний ажлын байрны тодорхойлолт болон ажилд томилогдсон тушаалыг хавсаргасан байна.

4.6. Газрын нэгдмэл сангийн мэдээллийн санд өөрчлөлт оруулах эрх бүхий мэргэжилтэн нь мэдээллийн санд өөрчлөлт оруулахдаа уг журмын дагуу 3.1-3.6-д заасны дагуу зураглаж бүртгэн, тухайн журмын хавсралт 1-ийн дагуу кодлон оруулна.

4.7. Мэдээллийн санд орж байгаа өөрчлөлт нь Засгийн газрын ангилал шилжүүлэх болон харьяалах шатны Засаг даргын дэлгэрэнгүй ангилал шилжүүлэх, газар олгох, газар ашиглалтын зориулалт өөрчлөх шийдвэрийг үндэслэсэн байх бөгөөд өөрчлөлтийг шийдвэр гарсан тухай бүр оруулна.

4.8. Газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллын шилжилт, хөдөлгөөний ажлын урсгалыг тухайн мэдээллийн сан дээр тохируулах бөгөөд тухайн тохиргооноос хамаарч шилжилт хөдөлгөөний төлөвүүд өөр байна.

4.9. Газрын нэгдмэл сангийн шилжилт, хөдөлгөөний ажлын зургийг бэлтгэхдээ тухайн нэгж талбарын газрын нэгдмэл сангийн ангиллын ажлын урсгалын дагуу өөрчлөлтийн бүртгэл хийж, Засгийн газрын тогтоолын төсөлд нэгтгэж оруулна.

4.10. Газрын нэгдмэл сангийн үндсэн ангилал шилжүүлэх тухай Засгийн газрын тогтоол батлагдсан тохиолдолд газрын нэгдмэл сангийн өөрчлөлтийн



төсөлд бүртгэлтэй байгаа нэгж талбарууд энэ журмын 4.12 дахь хэсгийн дагуу газрын нэгдмэл сангийн үндсэн давхаргад автоматаар бүртгэгдэж, газрын нэгдмэл сангийн ангилал өөрчлөгдөнө.

4.11. Засгийн газрын тогтоолоор бус /Үндсэн ангиллын шилжилт хөдөлгөөн биш/ өөрчлөлтийг Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэлтэй байгаа эсвэл шинээр бүртгэгдэж байгаа өөрчлөлт бүрт газрын нэгдмэл сангийн давхаргад өөрчлөлт орно.

4.12. Газрын кадастрын мэдээллийн санд шинээр бүртгэгдсэн боловч тэр үндсэн ангилал шилжиж байгаа, эсвэл холбогдох бусад хуулийн дагуу Засгийн газрын тогтоол гарах шаардлагатай бол газрын нэгдмэл сангийн давхаргад шууд өөрчлөлт оруулахгүй бөгөөд газрын нэгдмэл сангийн ажлын давхаргад шилжүүлж төсөлд оруулна.

4.13. Газрын нэгдмэл санд өөрчлөлт оруулахад давхацсан байршилтай нэгж талбаруудыг /Жишээ нь: автозам болон шугам сүлжээ, гол болон зам, гүүр гэх мэт/ Газрын нэгдмэл сангийн програм хангамжийн газрын нэгдмэл сангийн давхцалын тохиргооны бүртгэлийн дагуу өөрчлөлт оруулна.

4.14. Сумын газрын даамал, дүүргийн Газрын албаны холбогдох мэргэжилтнүүд Газрын нэгдмэл сангийн мэдээллийн сангийн мэдээ, мэдээллийг харах эрхтэй байх бөгөөд тухайн мэдээллийн сангийн өгөгдөл, мэдээллийг үндэслэн жил бүрийн газрын нэгдмэл сангийн тайлангийн "Газрын шилжилт хөдөлгөөний тэнцэл"-ийг гаргана. Газрын шилжилт хөдөлгөөний тэнцэл дээр суурилан тухайн нутаг дэвсгэрийн газрын нэгдмэл сангийн ангиллын тайланг гаргана.


Тав. Хяналт, хариуцлага

5.1. Газрын нэгдмэл сангийн ангиллын мэдээллийн санд оруулах мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлыг мэдээллийн санд өөрчлөлт оруулж буй мэргэжилтэн хариуцна.

5.2. Аймаг, нийслэлийн Газрын нэгдмэл сангийн ангиллын мэдээллийн сангийн хөтлөлт, өөрчлөлт оруулж буй байдалд агентлагийн Кадастрын хэлтсийн газрын нэгдмэл сангийн тоо бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн хяналт тавина.


5.3. Газрын нэгдмэл сангийн үндсэн ангиллын шилжилт хөдөлгөөний ажлын давхаргад бүртгэгдсэн нэгж талбаруудад програм хангамжийн шалгах үндсэн шалгууруудаас гадна эрх бүхий дээд байгууллагын мэргэжилтэнд шилжиж ирсэн төлөвийн дагуу шалгаж, дараагийн төлөвт шилжүүлнэ.

5.4. Газрын нэгдмэл сангийн тоо бүртгэлийн мэдээллийг зохих зөвшөөрөлгүйгээр хувиран тараасан, бусдад шилжүүлсэн, мэдээллийн санг хуулах, устгах, өөрчилсөн, өөрчлөхийг оролдсон буюу ажлын хариуцлага алдсан албан тушаалтанд хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцно.




ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН АНГИЛАЛ, КОД

Үндсэн ангилал	Код 1	Ангиллын түвшин 1	Код 2	Ангиллын түвшин 2 /ашиглалтын зориулалт/	Код 3	
Хөдөө аж ахуйн газар	1	Бэлчээр	11	өвөл-хаврын	1101	
				зун-намрын	1102	
				сум дундын отрын	1103	
				алслагдсан	1104	
				бартаа ихтэй	1105	
				усжуулагдаагүй	1106	
				хаддаг бэлчээр	1107	
				хуваарь сэлгээгүй ашиглаж буй бэлчээр	1108	
				нөөц бэлчээр	1109	
		Хадлан	12		ердийн	1201
					усалгаатай	1202
		Усалгаатай тариалан	13		үр тариа	1301
					төмс, хүнсний ногоо	1302
					тэжээлийн ургамал	1303
					техникийн ургамал /тосны/	1304
					жимс жимсгэнэ	1305
					эмийн болон гоёлын ургамал	1306
					цайны ургамал	1307
		Усалгаагүй тариалан	14		үр тариа	1401
					төмс, хүнсний ногоо	1402
					тэжээлийн ургамал	1403
					техникийн ургамал /тосны/	1404
					жимс жимсгэнэ	1405
					эмийн болон гоёлын ургамал	1406
					цайны ургамал	1408
		Атаршсан газар	15		50%-иас дээш ургамлан бүрхэвчтэй	1501
					50%-иас доош ургамлан бүрхэвчтэй	1502
		Хөдөө аж ахуйн барилга, байгууламжийн дэвсгэр газар	16		өвөлжөө, хаваржаа	1601
					мал эмнэлгийн үйлчилгээний цэг	1602
					үтрэм	1603
					ХАА-н машин, механизмын хашаа, гараж	1604
					тэжээл, бордооны агуулах	1605
					ХАА-н үйлдвэрлэлийн цогцолбор	1606
					хүлэмж, дарлага	1607
					тариалангийн талбай хоорондын зурвас газар	1608
					тариалангийн талбайн хамгаалалтын ойн зурвас	1609
					бэлчээр дэх уст цэг	1610
					зоорь, ХАА-н бүтээгдэхүүн хадгалах газар	1611
					усалгааны зориулалттай байгууламж	1612
					эрчимжсэн мал аж ахуйн ферм	1613
					тэжээвэр амьтны аж ахуй	1614




			зэрлэг амьтны аж ахуй	1615
			зөгийн аж ахуй	1616
			тахиа болон бусад шувууны аж ахуй	1617
			загасны аж ахуй	1618
			хөдөө аж ахуйн шинжлэх ухааны сорилт, туршилтын газар	1619
			уламжлалт МАА-н үйлдвэрлэлийн зориулалттай бусад газар	1620
			зоотехникийн үйлчилгээ, мал үржлийн цэг	1621
			ангийн отогийн байр	1622
	Ашиглахад тохиромжгүй газар	17	элсэн манхан, элсэрхэг газар	1701
			хад асга, шал сайр	1702
			ургамлан бүрхэвчгүй нүцгэн газар	1703
	Барилга, байгууламжийн доорх газар	21	төрийн захиргааны байгууллага	2101
			шинжлэх ухааны байгууллага	2102
			урлаг, соёлын байгууллага	2103
			боловсролын байгууллага	2104
			эрүүл мэндийн байгууллага	2105
			банк, санхүүгийн байгууллага	2106
			биеийн тамир, спортын байгууллага	2107
			нам, олон нийтийн байгууллага	2108
			сүм, хийд, шашны байгууллага	2109
			зочид буудлын цогцолбор, олон нийтийн газар	2110
			худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор	2111
			дэд бүтцийн байгууллага	2112
			музей, түүх, соёлын дурсгалт газар	2113
			гадаадын шашны байгууллагын газар	2114
			автомашинь засвар үйлчилгээний цэг	2115
			автомашинь гараж	2116
			шатахуун түгээх станц, агуулах	2117
			ус түгээх цэг	2118
			автотээврийн үйлчилгээний зориулалтын барилга, байгууламж	2119
			асрамжийн газрын барилга байгууламж	2120
			бүх төрлийн оффис, албан конторын зориулалттай барилга, байгууламж	2121
			нийтийн үйлчилгээний байгууллага	2122
			нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага	2123
			хууль, хүчний байгууллага	2124
			агуулах, агуулахын байгууламж	2125
	Суурьшлын газар	22	9 ба түүнээс дээш давхар нийтийн орон сууц	2201
			5-8 давхар нийтийн орон сууц	2202
			4 ба түүнээс доош давхар нийтийн орон сууц	2203
			амины орон сууц	2204
			гэр, орон сууцны хашааны газар	2205
			гэр бүлийн хэрэгцээний зуслангийн газар	2206
			үйлчилгээтэй орон сууц	2207




2


		орон сууцны дундын ашиглалтын газар	2208
		гэр бүлийн хэрэгцээнийхээс бусад зуслангийн газар	2209
Үйлдвэрийн газар	23	үйлдвэрлэл, технологийн парк	2303
		машин механизм, түүний эд ангийн үйлдвэрлэл	2304
		химийн бодис, резин, хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэл	2305
		газрын тос, нүүрсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	2306
		тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл	2307
		барилгын материал үйлдвэрлэл	2308
		хүнсний үйлдвэрлэл	2309
		нэхмэл эдлэл, хувцас, арьсан эдлэлийн үйлдвэрлэл	2310
		цаас, цаасан бүтээгдэхүүний үйлдвэрлэл	2311
		мод, модон бүтээгдэхүүн үйлдвэрлэл	2312
		металл үйлдвэрлэл	2313
		барилгын материал үйлдвэрлэл	2314
		нефть, хийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, агуулах	2315
		хог хаягдлын үйлдвэрлэл	2316
		хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах, үйлдвэрлэл	2317
Нийтийн эдэлбэрийн газар	24	иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшлийн бус амралт, зугаалга, биеийн тамирын зориулалтын газар	2401
		нийтийн эзэмшлийн ногоон байгууламж, цэцэрлэгжүүлж, зүлэгжүүлсэн талбай	2402
		цэнгэлдэх хүрээлэн, наадмын талбай	2403
		нэрэмжит талбай, хөшөө, дурсгалын газар	2404
		тоглоомын талбай	2405
		эзэмшил, ашиглалтанд олгогдоогүй сул чөлөөтэй газар	2406
		хогийн цэг	2407
		оршуулгын газар	2408
		нийтийн эзэмшлийн бусад газар	2409
		морин уралдааны бариа, автоспортын уралдааны газар	2410
		нурсан барилга, балгас	2411
		усан оргилуур	2412
		нийтийн эзэмшлийн зам, талбай	2413
Амралт, аялал жуулчлалын газар	25	хүүхдийн зуслан	2501
		амралтын газар	2502
		аялал, жуулчлалын бааз	2503
		рашаан, сувиллын газар	2504
		биеийн тамирын зориулалттай гадаа талбай, спортын барилга, байгууламж	2505
Уурхайн газар	26	ашиглалт, олборлолт явуулж буй талбай	2601
		уул уурхайн үйлдвэрлэлийн барилга, байгууламж	2602
		уурхайн нөөц газар	2603
		уул уурхайн тэсэрч дэлбэрэх бодисын агуулах	2604



Зам, шугам сүлжээний газар			уул уурхайн хүнд тоног төхөөрөмжийн агуулах, засвар үйлчилгээ	2605	
			уурхайн суурьшлын бүс	2606	
			нүүрс болон бусад ашигт малтмал ачиж буулгах талбай, терминал	2607	
			ашигт малтмалын гаалийн хяналтын талбай	2608	
		Хот суурин доторх бүх төрлийн зам, тэдгээрийн барилга байгууламжийн газар	27	автозам	2701
			автомашинны зогсоол	2702	
			төмөр зам	2703	
			унадаг дугуйн зам	2704	
			явган хүний зам	2705	
		Хот суурины доторх инженерийн дэд бүтцийн зориулалтын газар	28	инженерийн шугам сүлжээ	2801
			инженерийн байгууламж	2802	
			нисэх буудал, аюулгүйн зурвас	2803	
		үерийн далан, суваг	2804		
	Цаашид тэлж хөгжих нөөц газар	29	цаашид тэлж хөгжих нөөц газар	2901	
		Төмөр замын газар	31	төмөр зам бүхий далан	3101
				хамгаалалтын зурвас	3102
				галт тэрэгний өртөө, зөрлөгийн барилга байгууламж	3103
				төмөр замын гарам	3104
				ачаа ачих, буулгах талбай	3105
				төмөр замын гаалийн хяналтын талбай	3106
		Авто замын газар	32	авто тээврийн хэрэгслийн зогсоолын талбай	3202
				хатуу хучилттай зам	3203
				сайжруулсан шороон зам	3204
				ердийн шороон зам	3205
				сургалт, дадлагын талбай	3206
				авто замын барилга, байгууламж	3207
				тусгай зориулалтын зам	3208
				автозамын зурвас газар	3209
олон улсын, улсын, орон нутгийн чанартай автозамын тээврийн хэрэгсэлийн түр зогсоолын талбай				3210	
автозамын газарт хамаарах гаалийн хяналтын талбай				3211	
Агаарын тээврийн газар		33	нисэх, буух зурвас	3301	
			хамгаалалтын зурвас, аюулгүйн бүс	3302	
			агаарын тээврийн барилга, байгууламж, төхөөрөмжийн талбай	3303	
			нисэх буудал, аэродром	3304	
Шугам, сүлжээний газар		34	холбоо, мэдээлэл дамжуулах хүлээн авах станц, шугам	3401	
			эрчим хүч, дамжуулах шугам, станц	3402	
			газар дээрх дулаан дамжуулах хоолой	3403	
			газар дээрх нефть, хий дамжуулах хоолой	3404	
			үйлдвэрийн болон аж ахуйн зориулалтын усан сан	3405	
			ус түгээх, шахах, өргөх байгууламж, хоолой	3406	
			үерээс хамгаалах суваг далан	3407	



			ус дамжуулах шугам сүлжээ	3408	
			цэвэрлэх байгууламж, ариутгах татуурга	3409	
			цахилгаан, эрчим хүч дамжуулах шугам	3410	
			холбоо мэдээлэл дамжуулах шугам	3411	
			ус хангамжийн барилга байгууламж	3412	
			цахилгаан, эрчим хүчний барилга байгууламж	3413	
			харилцаа, холбооны барилга, байгууламж	3414	
			бохирын усны усан сан бүхий газар	3415	
	Усан тээврийн газар	35	усан тээврийн барилга, байгууламж	3501	
			усан тээврийн бусад газар	3502	
			усан тээврийн зогсоолын газар	3503	
Ойн сан бүхий газар	4	Ой модоор бүрхэгдсэн газар	41	ой модоор бүрхэгдсэн	4101
				заган ойгоор бүрхэгдсэн	4102
				таримал ой, ойжуулалт хийгдэж буй газар	4103
				мод үржүүлгийн газар	4104
	4	Ой дотор байгаа ойгоор бүрхэгдээгүй газар	42	модыг нь огтолсон талбай	4201
				ойн цоорхой	4202
				түймэрт өртсөн, шатсан ой	4203
				ой тэлэн ургах боломжийг хангахуйц газар	4204
Усны сан бүхий газар	5	Мөрөн, гол, горхи	51	мөрөн, гол, горхи	5101
		Булаг, шанд	52	булаг, шанд	5201
			рашаан	5202	
	5	Нуур, цөөрөм, тойром	53	нуур, тойром	5301
				хиймэл нуур	5302
				хөв, цөөрөм	5303
		Мөнх цас, мөсөн гол	54	мөнх цас, мөсөн гол	5401
		Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс	55	усны сан бүхий газрын хамгаалалтын бүс	5501
		Улсын тусгай хамгаалалттай газар	61	дархан цаазат газар	6101
				байгалийн цогцолборт газар	6102
				байгалийн нөөцийн газар	6103
				дурсгалт газар	6104
		Улсын хилийн зурвас газар	62	улсын хилийн зурвас газар	6201
		Улсыг батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар	63	улсыг батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар	6301
		Гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт олгосон газар	64	гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт олгосон газар	6401
	Шинжлэх ухаан, технологийн сорилт туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын	65	шинжлэх ухаан, технологийн сорилт туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай	6501	



Улсын тусгай хэрэгцээний газар	6	Аймаг дундын отрын бэлчээр	66	аймаг дундын отрын бэлчээр	6601
		Улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай	67	улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай	6701
		Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хайгуулын зориулалтаар ашиглах газрын тосны гэрээт талбай	68	бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хайгуулын зориулалтаар ашиглах газрын тосны гэрээт талбай	6801
		Чөлөөт бүсийн газар	69	чөлөөт бүсийн газар	6901
		Цөмийн төхөөрөмж барих, ашиглах зориулалтаар олгосон газар	70	цөмийн төхөөрөмж барих, ашиглах зориулалтаар олгосон газар	7001
		Бичил уурхайн зориулалтаар олгосон газар	71	бичил уурхайн зориулалтаар олгосон газар	7101
		Хилийн боомтын бүс	72	хилийн боомтын бүс	7201
		Үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх газар	73	үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх газар	7301
		Аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих газар	74	аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих газар	7401
		Хамгаалалтын бүс тогтоосон түүх, соёлын дурсгалт газар	75	хамгаалалтын бүс тогтоосон түүх, соёлын дурсгалт газар	7501
	Үйлдвэрлэл, технологийн паркийн газар	76	үйлдвэрлэл, технологийн паркийн газар	7601	




**ХОТ ТОСГОН, БУСАД СУУРИН ГАЗРЫН ГАЗАР АШИГЛАЛТЫН
ЗОРИУЛАЛТЫН АНГИЛАЛ, КОД**

Код 2	Ашиглалтын зориулалт	Код 3	Үйл ажиллагааны чиглэл	Код 4
	төрийн захиргааны байгууллага	2101	Төрийн байгууллага, албан газрын зайлшгүй хэрэгцээний зориулалт	210101
			Төрийн өмчит үйлдвэрийн газрын зайлшгүй хэрэгцээний зориулалт	210102
			Төрийн байгууллагын сургалт, дадлагын талбай, байгууламж	210103
			Орон нутгийн захиргааны газар	210104
	шинжлэх ухааны байгууллага	2102	Эрдэм шинжилгээний хүрээлэн, байгууллага	210201
			Судалгаа, шинжилгээний байгууллага	210202
			Одон орон судлалын төв	210203
	урлаг, соёлын байгууллага	2103	Номын сан, түрээсийн номын үйлчилгээ	210301
			Концерт, дуурь, бүжгэн жүжиг, драмын	210302
			Кино театр	210303
			Задгай кино театр	210304
			Соёлын төв	210305
